



БАНКНЫ САЛБАРЫН ШИНЭТГЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нэг талаас банкны салбарын өөрийн хөрөнгө нэмэгдэн эрүүлжиж, эрсдэл даах чадвар сайжирч, өмчлөл нь олон улсын жишгийн дагуу олон нийтийн өмчийн хэлбэрт шилжиж, банкуудад тавих хөндлөнгийн хяналт нэвтэрч, үйл ажиллагаа нь ил тод тунгалаг болж, зохистой засаглалын гол хүчин зүйл болох шийдвэр гаргах, гүйцэтгэх, хяналт тавих эрх мэдэл хуваагдаж, харилцан бие биедээ хяналттай, тэнцвэртэй эрх мэдэлтэй байх зарчим бий болж, дотоод хяналтын

тогтолцоо хангагдана; нөгөө талаас олон улсын стандарт, сайн туршлагад нийцсэн зохицуулалтын эрх зүйн орчин бүрдэж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлнэ; эдгээрийн үр дүнд гадаад дотоодын хөрөнгө оруулагч нарын банканд итгэх итгэл нэмэгдэж, санхүүгийн зуучлал өргөжин гүнзгийрч, улмаар банкны систем эдийн засгийн урт хугацааны тогтвортой, хүртээмжтэй эерэг өсөлтөд зохих хувь нэмрээ оруулах болно.

БАНКНЫ САЛБАРЫН ШИНЭТГЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУД

ЗОРИЛТ 1

Банкны салбарын хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, банкны үйл ажиллагааны зохистой засаглалыг сайжруулан ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай банкны тогтолцоог бий болгох

ЗОРИЛТ 2

Банкны хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын жишигт нийцүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн эрүүл, найдвартай банкны тогтолцоог бий болгох

ЗОРИЛТ 3

Олон улсын мэргэжлийн байгууллагуудтай хийх хамтын ажиллагааг үргэлжлүүлж, дараагийн санхүүжилтийн хөтөлбөрт бэлтгэх

ЗОРИЛТ 4

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх, эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах, ФАТФ-ын саарал жагсаалтаас гарах, дараагийн харилцан үнэлгээнд бэлтгэх

ЗОРИЛТ 5

Банкны үйл ажиллагааны чиглэл, бизнесийн загвар болон бусад онцлог хүчин зүйлд тулгуурлан банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, тавигдах шаардлагыг төрөлжүүлэн харилцагчид хүртээмжтэй, цахимжсан банкны тогтолцоог бий болгох

БАНКНЫ САЛБАРЫН ШИНЭТГЭЛИЙН ХӨТӨЛБӨРӨӨС ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

Банкны хувь эзэмшлийн төвлөрөл буурснаар хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц төрөлжиж, өөрийн хөрөнгийн хүрэлцээг хангахад шаардлагатай эх үүсвэрийг олон нийтийн оролцоо, хяналттайгаар түргэн хугацаанд төвлөрүүлэх боломжийг бүрдүүлж, зохистой засаглал сайжран харилцагч, хадгаламж эзэмшигч, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын банканд итгэх итгэл нэмэгдэх

Олон улсын жишигт нийцсэн журам, заавар, банкны зохицуулалт, үр нөлөөтэй албадлагын арга хэмжээ бүхий эрх зүйн орчныг бий болгож, эрсдэлд суурилсан, уян хатан хяналт зохицуулалтын орчныг бүрдүүлэх

Банкуудын өөрийн хөрөнгө нэмэгдэж, банкны системийн эрсдэл даах чадвар сайжирснаар найдвартай, тогтвортой банкны тогтолцоо бүрдэж, эдийн засгийн урт хугацааны өсөлтийг дэмжих

Мөнгө Угаах, Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх (МУТС) тогтолцоог боловсронгуй болгосноор МУТС-ын тогтолцооны хувьд үүссэн стратегийн дутагдлыг шийдвэрлэж, цаашид ФАТФ болон бусад олон улсын байгууллагаас хийх үнэлгээг сайжруулах

Банкны үйл ажиллагааны төрөл, хөрөнгө, эх үүсвэрийн хэмжээ, газарзүйн байршил, харилцагчдын суурь, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ нь техник технологийн дэвшилд түлхүү суурилсан эсэхээс хамааруулж банкны тусгай зөвшөөрлийг төрөлжүүлэн олгож, пропорциональ хяналт шалгалтын зарчмыг нэвтрүүлэх

ЗОРИЛТ 1

Банкны салбарын хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгож, банкны үйл ажиллагааны зохистой засаглалыг сайжруулан ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай банкны тогтолцоог бий болгох

СТРАТЕГИ

- Банкны салбар дахь хувь эзэмшлийн төвлөрлийг тархаах арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Хувь эзэмшлийн төвлөрөлд тавигдах шинэ шаардлага, шалгуур үзүүлэлтийг Монгол улсын банкны салбарын онцлог, хөрөнгийн захын хөгжил зэрэг бусад хүчин зүйлүүдийг харгалзан тогтоох
- Хууль тогтоомжид өөрчлөлт оруулахдаа бусад зохицуулагч байгууллагуудтай хамтран ажиллах (СЗХ, Хөрөнгийн бирж гэх мэт)

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Монголын арилжааны банкны салбар, хөрөнгийн захын үйл ажиллагааны нөхцөл байдлыг харгалзан Банкны тухай хуульд дараах агуулга бүхий хязгаарлалтыг нэмж тусгах:

- Банкнийг Хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК)-ийн хэлбэрээр үүсгэн байгуулахыг хориглож, зөвхөн Хувьцаат компани (нээлттэй эсвэл хаалттай)-ийн хэлбэрээр байгуулах шаардлагыг заавал биелүүлэх нөхцөлтэйгөөр тусгах
- Нэг хувьцаа эзэмшигч (иргэн, хуулийн этгээд), түүнтэй холбоотой этгээд, харилцан хамаарал бүхий этгээдээс өмчлөх банкны саналын эрхтэй хувьцаа, хувьцаанд хөрвөх нөхцөлтэй үнэт цаасны нийлбэр дүнд дээд хязгаар тогтоох
- Банкнийг үүсгэн байгуулснаас хойш тодорхой хугацааны дотор нээлттэй эсвэл хаалттай захиалгын хэлбэрээр банкны саналын эрхтэй хувьцаа, түүнд хөрвөх үнэт цаасыг Монголбанкнаас хүлээн зөвшөөрсөн хөрөнгийн биржид нээлттэй (public offer/trade) эсвэл хаалттай (private placements) хэлбэрээр гаргах, арилжихыг шаардах
- Хуулийн нэмэлт өөрчлөлтийг батлах үеийн байдлаар нэг хувьцаа эзэмшигчид тавих хязгаарлалтаас хэтэрсэн хувь эзэмшлийг тодорхой хугацааны дотор (4-7 жилийн хугацаанд хэрэгжүүлэх) Монголбанкнаас хүлээн зөвшөөрсөн хөрөнгийн бирж дээр нээлттэй эсвэл хаалттай хэлбэрээр худалдах

- Хувь эзэмшлийн хязгаарлалт үйлчлэхгүй байх онцгой нөхцөлүүдийг тодорхойлж, Банкны тухай хуульд тусгах
- Хувь эзэмшлийн төвлөрөлд тавигдах шаардлага, хязгаарлалтыг зөрчсөн эсвэл заасан хугацаанд хангаагүй банканд авч хэрэгжүүлэх зохицуулалтын арга хэмжээг Банкны тухай хуулийн Албадлагын арга хэмжээний хэсэгт тусгах
- Тодорхой үнийн дүнгийн болон бусад шаардлага хангасан банкны жижиг хувьцаа эзэмшигчид (саналын эрхтэй хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаас эзэмшигч)-ийг тодорхойлох, Банкныг албадан татан буулгаж, төлбөр барагдуулах тохиолдолд төлбөр барагдуулах дараалалд орох эрэмбийг даатгагдаагүй хадгаламжтай зэрэгцүүлэн тогтоох

ЗОРИЛТ 2

Банкны хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын жишигт нийцүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн эрүүл, найдвартай банкны тогтолцоог бий болгох

СТРАТЕГИ

- Банкны зохистой харьцаа, активын ангилал, төлбөрийн чадварын үзүүлэлт болон хяналт шалгалтын хүрээнд банкуудад тавих шаардлагыг Базелын цуврал стандарттай нийцүүлэн нэвтрүүлэх
- Банкны салбарын эрсдэл даах чадвар болон тогтвортой өсөлтийг хангах зорилгоор банкны хяналт шалгалтын хүрээнд тогтоосон олон улсын стандарт, банкны тухай хууль тогтоомжийг оновчтой хэрэгжүүлэхэд Монголбанкнаас эрх бүхий бусад байгууллагатай хамтран ажиллах
- Хяналт шалгалтын аргачлалыг эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх үүднээс эрх зүйн орчныг бүрдүүлэх
- Хяналт шалгалтын үйл ажиллагааг хувь тэнцүүлэх зарчмын дагуу явуулахад анхаарах

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Банкуудын өөрийн хөрөнгийн дотоод үнэлгээ, удирдлагыг оновчтой хийх чадварыг бэхжүүлэх үүднээс Базел стандартын Бүлэг 2-ын банкууд өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ICAAP)-ыг журамд тусган, ингэхдээ банкны системд үзүүлэх нөлөө, эрх зүйн орчин зэрэгтэй уялдуулан хэрэгжүүлэх хугацааг тогтоох
- Эрсдэл хамгаалах нөөц, хөшүүргийн харьцаа болон төвлөрлийн эрсдэлийг бууруулах зохистой харьцаа зэрэг банкны үйл ажиллагаанд шинэчлэн тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг банкуудад нэвтрүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
- Банкны өөрийн хөрөнгийн шаардлагад энгийн хувьцаа болон нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн жинг нэмэгдүүлж, банкны үйл ажиллагааны зохистой харьцааны талаар баримтлах бодлого, чиглэлийн талаар банк, олон нийтэд мэдээлэх
- Чанаргүй активыг бууруулах зорилтын хүрээнд зээл олголтын зарчим, барьцаа хөрөнгийн үнэлгээг олон улсын жишигт нийцүүлэх журмуудыг батлан мөрдүүлэх

- Банкны тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг дагалдан гарах банкны тогтворжуулалтын сан бүрдүүлэлт, түүний зарцуулалт, хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулах журам, банкуудаас банкныг тогтворжуулах болон Монголбанкнаас банкны бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх журмыг олон улсын сайн туршлагад үндэслэн тус тус боловсруулж, батлах
- Базел стандартын Бүлэг 3-ыг нэвтрүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх
- Олон улсад мөрдөж буй санхүүгийн хэрэглүүрийг ангилах, хэмжих, түүний үнэ цэнийн бууралтыг тооцох тухай санхүүгийн тайлагналын олон улсын 9 дүгээр стандартыг банкуудад мөрдүүлэхээр нягтлан бодох бүртгэлийн багц материалыг шинэчлэн боловсруулах ажлыг эхлүүлэх
- Базел III стандартын мөчлөг сөрсөн бодлогын хэрэгсэл буюу эдийн засгийн нөхцөл байдалтай уялдсан нөөц интервал (counter-cyclical buffer), банкуудын богино хугацааны төлбөрийн чадварын удирдлагыг сайжруулж, санхүүжилтийг тогтворжуулах хөрвөх чадварын (LCR) болон тогтвортой санхүүжилтийн харьцааг (NSFR) нэвтрүүлэх боломжийг судлах
- Зах зээлийн эрсдэлийг өөрийн хөрөнгийн тооцоонд оруулах
- Базел стандартын Бүлэг 2-ын хяналт шалгалтын үнэлгээний аргачлалыг (SREP) нэвтрүүлэх зорилгоор холбогдох журмыг шинэчлэх. Энэ хүрээнд макро стресс тест, банкуудын бизнес загварын үнэлгээг гүйцэтгэхээс гадна төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг банкууд дотооддоо үнэлэх аргачлалыг (ILAAP) Базел III стандартын хөрвөх чадварын зохистой харьцааг нэвтрүүлэх хугацаатай уялдуулах
- Банкны зохистой засаглалын журмыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулах

ЗОРИЛТ 3

Олон улсын
мэргэжлийн
байгууллагуудтай
хийх хамтын
ажиллагааг
үргэлжлүүлж,
дараагийн
санхүүжилтийн
хөтөлбөрт бэлтгэх

СТРАТЕГИ

- Банкны өөрийн хөрөнгийн дутагдлыг хууль тогтоомжид заасан шаардлага хангасан эх үүсвэрээр бүрдүүлэхэд анхаарч ажиллах
- Банканд өөрийн хөрөнгийн дутагдлыг нэмэгдүүлэх хөшүүрэг бий болгох буюу өөрийн хөрөнгийн шаардлагыг биелүүлэх хүртэл банкны үйл ажиллагаанд хуулийн дагуу хязгаарлалт хийх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан авах
- Монголбанкны шаардлагыг хангалтгүй биелүүлсэн банканд банкны тухай хууль тогтоомжийн дагуу шаардлагатай арга хэмжээг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан авч хэрэгжүүлэх
- Банкны тухай хууль тогтоомжийн хүрээнд банканд авах албадлагын арга хэмжээний талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлтэй хамтарч ажиллах
- ОУВС-ийн дараагийн санхүүжилтийн хөтөлбөрийн урьдач шаардлага, нөхцөлийг хангахад шаардлагатай арга хэмжээг авч ажиллах

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Банкны нэмэгдүүлсэн өөрийн хөрөнгийн эх үүсвэрийг магадлан баталгаажуулж, хууль тогтоомжид заасан шаардлага хангасан эх үүсвэр эсэхийг тогтоох
- Банкны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээг банк өөрийн хөрөнгийг тогтоосон хэмжээгээр нэмэгдүүлэх хүртэл эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан шат дараатайгаар авч хэрэгжүүлэх
- Банкны тогтворжуулах төлөвлөгөөг гаргуулан авч, үнэлэх, биелэлтийг хангуулах
- Болзошгүй албадлагын арга хэмжээний бэлтгэлийг хангаж, төлөвлөгөө боловсруулах
- ОУВС-ийн дараагийн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдах шаардлага, нөхцөлийг тухай бүр ханган ажиллах

СТРАТЕГИ

- Мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкны салбарын зохицуулалт, түүний хэрэгжилтэд тавих хяналт шалгалтын үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Хуульчдын холбоо, Нотариатчидын танхимын хяналт шалгалтын үйл ажиллагааг дэмжиж ажиллах
- Арилжааны банкуудын корреспондент банкны харилцааг дэмжиж ажиллах
- Санхүүгийн салбарт технологийн дэвшлийг ФАТФ-ын 40 зөвлөмжид нийцтэйгээр нэвтрүүлэх болон Мөнгө угаахтай тэмцэх Ази, Номхон далайн бүсийн байгууллагын өргөтгөсөн хяналтаас гарахад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Банкны хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгийн гарал үүсэлд тавих шаардлага, хяналт шалгалтыг сайжруулах, дотоод, гадаадын эрх бүхий байгууллагатай хяналт шалгалтын зорилгоор мэдээлэл солилцох хамтын ажиллагааг хөгжүүлэх.

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Арилжааны банкуудын корреспондент харилцааг дэмжих зорилтын биелэлтэд ФАТФ-ын саарал жагсаалтаас богино хугацаанд гарах хүрээнд:

- Төрийн дээд хэмжээний айлчлал, олон улсын санхүүгийн байгууллагууд болон дипломат шугамаар хийгдэх хоёр талт уулзалт ярианы сэдэвт корреспондент банкны харилцаатай холбоотой асуудлыг тусгах, дэмжлэг хүсэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, тэднийг шаардлагатай мэдээллээр хангах
- Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үр дүнгийн талаар англи хэл дээр мэдээлэл бэлтгэн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах

ЗОРИЛТ 4

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх, эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах, ФАТФ-ын саарал жагсаалтаас гарах, дараагийн харилцан үнэлгээнд бэлтгэх

- Банкууд мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод бодлого, журам, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа, гадаад төлбөр тооцооны гүйлгээнд тавих шаардлагын талаарх мэдээллийг англи хэл дээр өөрсдийн цахим хуудсанд байршуулах, гүйлгээтэй холбоотойгоор корреспондент банкнаас ирүүлсэн нэмэлт мэдээлэл, тодруулга авах хүсэлтэд шуурхай хамтран ажиллаж чадаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах
- Системийн ач холбогдол бүхий банкууд мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаандаа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүнд бүхий аудитын компаниар нийцлийн аудит хийлгэх, аудитын тайланг цахим хуудсандаа байршуулахыг зөвлөх

Санхүүгийн салбарт технологийн дэвшлийг ФАТФ-ын 40 зөвлөмжид нийцтэйгээр нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх, Мөнгө угаахтай тэмцэх Ази Номхон далайн бүсийн байгууллагаас хийх дараагийн харилцан үнэлгээг сайжруулах, дахин эдгээр байгууллагын хяналтад орохгүй байхад урьдчилан сэргийлэх хүрээнд:

- Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Банк эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах
- Виртуал хөрөнгийн зохицуулалтыг бий болгох,
- Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн гарал үүсэл, хувьцаа эзэмшигчид тавих шаардлагыг ФАТФ-ын 40 Зөвлөмжид нийцүүлэн сайжруулах,
- Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн гарал үүсэл, хувьцаа эзэмшигчид тавигдах шаардлагыг хангасан талаар банкнаас ирүүлсэн баримт, мэдээллийн үнэн бодит байдлыг хараат бусаар нягтлах зорилгоор гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн гарал үүсэл, хувьцаа эзэмшигчид тавигдах шаардлагыг хангаагүй, тогтоогдохгүй байгаа тохиолдолд баримтлах, бодлого, журмыг тодорхой болгох

- ФАТФ-ын 40 Зөвлөмжид орж байгаа нэмэлт өөрчлөлт бүрийг судалж дотоодын хууль эрх зүйн орчныг нийцүүлэх ажлыг эхлүүлэх
- Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг шинэчлэн хийх
- Санхүүгийн болон санхүүгийн бус мэргэжлийн ажил, үйлчилгээ эрхлэгчдийн салбарын эрсдэлийн үнэлгээг шинэчлэн хийх
- Мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд оролцогч байгууллага бүр статистик, тоо баримтын бүртгэлийг хөтөлж хоорондын уялдаа, чиг хандлага, өөрчлөлтийг анхаарч ажиллах
- Мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн сургалт, сурталчилгааны ажлыг Хамтын ажиллагааны зөвлөлийн хүрээнд төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлэх
- Мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллагууд бүгд эрсдэлд суурилсан арга хэлбэрийг бүрэн нэвтрүүлэх, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллах
- Санхүүгийн мэдээллийн албаны дүн шинжилгээ хийх, хууль сахиулах байгууллагад шилжүүлж байгаа сэжигтэй гүйлгээний тоо, чанарт бодитой ахиц гаргах
- Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах

ЗОРИЛТ 5

Банкны үйл ажиллагааны чиглэл, бизнесийн загвар болон бусад онцлог хүчин зүйлд тулгуурлан банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, тавигдах шаардлагыг төрөлжүүлэн харилцагчид хүртээмжтэй, цахимжсан банкны тогтолцоог бий болгох

СТРАТЕГИ

- Банкны үйл ажиллагааны төрөл, хэмжээ, харилцагчдын суурь зэргээс шалтгаалан банкны үйл ажиллагааны зөвшөөрлийг төрөлжүүлэн олгодог, эрсдэлд суурилсан уян хатан хяналт зохицуулалтын орчныг бүрдүүлэх
- Банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг банкны үйл ажиллагааны чиглэл, хөрөнгийн хэмжээ болон бусад хүчин зүйлийг харгалзан ялгавартайгаар олгох хууль, эрх зүйн орчныг оновчтой бүрдүүлэх
- Финтек буюу санхүүгийн технологийг банкны салбарт оновчтой нэвтрүүлэх, харгалзах хяналт шалгалтын аргачлалыг нийцүүлэх

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Үйл ажиллагааны хувьд төрөлжсөн банканд тавигдах хувь нийлүүлсэн хөрөнгө, өөрийн хөрөнгө болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг ялгавартайгаар тогтоох зохицуулалтыг Банкны тухай хуульд нэмж тусгах
- Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг банкны үйл ажиллагааны чиглэл, цар хүрээнд нийцүүлэн ялгавартайгаар тогтоох
- Банкны үйл ажиллагааны зөвшөөрлийг газар зүйн байршил, бүс нутгийн хувьд төрөлжүүлэн олгох урьдач нөхцөл, хууль эрх зүйн орчныг хэрхэн бүрдүүлэх, энэ төрлийн банк үүсгэн байгуулах болон үйл ажиллагааны зохистой харьцааны шаардлагыг хэрхэн тогтоож, хяналт шалгалтыг хэрхэн гүйцэтгэх талаар судалж, бодлого, төлөвлөгөөг боловсруулах»
- Финтек буюу санхүүгийн технологид тулгуурлан үйл ажиллагаа эрхлэх банк болон дижитал банкны салбарт олгох тусгай зөвшөөрөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг зохицуулсан журам, зааврыг боловсруулж, мөрдүүлэх, Монголбанкнаас энэ төрлийн банк санхүүгийн байгууллагад оновчтой хяналт тавих буюу Регтекийг хяналт шалгалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх
- Санхүүгийн технологид тулгуурласан банкны арилжаа гүйлгээ болон харилцагчдын мэдээллийг хадгалах, солилцох, нууцлалыг хадгалахтай холбоотой шаардлагыг боловсруулж, холбогдох журам боловсруулж, нэвтрүүлэх